



АЗИЙН ХОТУУДЫН ТЭГШ БУС БАЙДАЛД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨЛӨЛ

**Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын
хөдөлмөр эрхэлдэг эхчүүдийн дунд хийсэн
судалгаа**

2021 оны 7 дугаар сар



The Asia Foundation



Australian Government

Department of Foreign Affairs and Trade

ЗОХИОГЧ: Норовсамбуугийн Ариунаа, Болдбаатарын Халиун, Дүгэрсүрэнгийн Оргил, Цэдэнгийн Цэцэгжаргал

БОЛОВСРУУЛСАН: Азийн Сангийн Бүс Нутгийн Засаглалын Баг

Энэхүү тайланг Азийн хотуудын тэгш бус байдлын талаарх бүс нутгийн судалгааны төслийн хүрээнд бэлтгэн гаргав. Судлаач/судалгааны баг нь судалгааны бүхий л шатанд томилогдсон ментортой хамтран ажиллаж, судалгааны үйл явцад дэмжлэг авч ажилласан. Энэхүү үйл явцад хувь нэмэр оруулсан Кор Глобал (Kore Global) байгууллагын Ребекка Калдер (Rebecca Calder), Салли Невилл (Sally Neville) болон Мандакини Л.Сури (Mandakini D.Surie) нарт талархал илэрхийлье.

Энэхүү судалгааг Азийн Сан болон Австралийн Гадаад Харилцаа, Худалдааны Яамны (DFAT) түншлэлийн хүрээнд санхүүжүүлэн гүйцэтгэлээ. Тайланд илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлэх ба Азийн Сан, Австралийн Гадаад Харилцаа, Худалдааны Яам эсвэл Австралийн Засгийн газрын үзэл бодлыг илэрхийлээгүй болно.



Энэхүү бүтээл нь Creative Commons Attribution-Non Commercial 4.0 олон улсын лицензийн хүрээнд хамаарна.



456 California Street, 9th Floor
San Francisco, CA U.S.A 94104
www.asiafoundation.org

ХАВТАСНЫ ЗУРАГ: Хоол хийж буй эмэгтэй, Улаанбаатар хот, Монгол улс (Эх сурвалж: Javier Gallego, Flickr)

АГУУЛГА

Тойм	2
Танилцуулга	4
5С: КОВИД-19 цар тахлын үеэрх хотуудын нөхцөл байдал, капитал болон чадамж	5
1. НӨХЦӨЛ БАЙДАЛ: КОВИД-19 ЦАР ТАХЛЫГ ХЯЗГААРЛАХ АЛХМУУД	6
КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ НЬ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ХҮҮХЭДТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮДЭД СӨРӨГ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЖЭЭ	7
2. ГЭР БҮЛДЭЭ ДЭМ ТУС БОЛОХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БОЛОМЖ БУУРСАН НЬ САНХҮҮГИЙН КАПИТАЛЫН ХОМСДОЛД ХҮРГЭЖЭЭ	9
ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮР АШИГ МУУТАЙ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ	9
ЦАР ТАХЛААС ҮҮДСЭН САНХҮҮГИЙН ХҮЧТЭЙ СӨРӨГ НӨЛӨӨ	10
3. ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ТУЛГАРСАН ХҮҮХЭД АСРАХ ХАРИЛЦАН ЯЛГААТАЙ СОРИЛТУУД	
УЯН ХАТАН БУС АЖЛЫН НӨХЦӨЛ НЬ ЭМЭГТЭЙЧҮҮД ЦАЛИНГАА БҮРЭН АВЧ ЧАДАХГҮЙД ХҮРГЭЖЭЭ ГЭР БҮЛИЙН ОЙРЫН ГИШҮҮДИЙН ДЭМЖЛЭГ ЧУХАЛ ШААРДЛАГАТАЙ БАЙЖЭЭ	14 15
4. ЧАДАМЖ: ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЧАДАМЖИЙН АРД УРТ ХУГАЦААНЫ ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦААНЫ ХЭРЭГЦЭЭ НУУГДАЖ БАЙНА	16
СТРЕСС, ГЭМШИЛ, ТУСГААРЛАЛТ БОЛОН АЖИЛ ОЛГОГЧДЫН ОЙЛГОЛТ ДУТМАГ БАЙДАЛ	17
УР ЧАДВАР АХИУЛАХ, АЛБАН ТУШААЛ ДЭВШИХЭД СААД УЧРУУЛАХ НЬ	17
5. БОДЛОГЫН НӨЛӨӨЛӨЛ	19
ХАВСРАЛТ: АРГА ЗҮЙ	21
Баримт бичгийн судалгаа	21
Хагас бүтэцлэгдсэн ярилцлага	21
Судалгааны ёс зүй	21
Сорилтууд болон хязгаарлалтууд	21
ТЭМДЭГЛЭЛ	22

ТОЙМ

КОВИД-19 халдварт цар тахал болон өвчлөлийг зогсоохын тулд Засгийн газрын зүгээс хэрэгжүүлсэн арга хэмжээ нь Монголчуудын эдийн засаг, нийгмийн амьдралд, ялангуяа хөдөлмөр эрхэлдэг эхчүүдэд олон хэлбэрээр нөлөөлжээ. УОК-ын шийдвэрээр 2020 оны 1 дүгээр сард сургуулийн өмнөх насны боловсролын бүх байгууллага, бага, дунд, ахлах сургуулиудын үйл ажиллагааг зогсоож, хөл хорио, хязгаарлалтын хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Энэ хөл хорионы хугацаанд бүх шатны сургуульд суралцагсад телевизийн болон цахим хөтөлбөрт гэрээсээ хамрагджээ. Зарим их, дээд сургууль 2020 оны 5 дугаар сард эргэн нээгдэж, үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэн ч 16-аас доош насны хүүхдүүдийн хувьд сургуулиуд олон сарын туршид хаалттай байсан.

Энэхүү тайланд сургуулиудын үйл ажиллагааг зогсоосон болон цар тахлыг хязгаарлах бусад арга хэмжээ нь бага насны хүүхэдтэй иргэдэд үзүүлсэн олон янзын нөлөөлөл, ялангуяа хүүхэд харах болон ажлаа зохицуулахтай холбоотой асуудлаас үүдсэн нөлөөллийг судлан үзсэн. Халдвар тархалтыг бууруулах зорилгоор Засгийн газраас сургуулиудын үйл ажиллагааг зогсоосонтой холбоотойгоор төв болон орон нутгийн захиргаа олон тооны тогтоол, тушаал гаргаж мөрджээ. 2020 оны 2 дугаар сард Засгийн газрын тогтоолын дагуу төв, орон нутгийн төрийн байгууллагад ажиллаж буй 12 хүртэлх насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчдын ажлын цагийг Улаанбаатар хотын хэмжээнд нэг цагаар бууруулан тогтоосон. Түүнчлэн, Засгийн газрын тогтоолоор 5-аас доош насны, амьсгалын замын халдварт өвчтэй, эсвэл Ковидын халдварын шинж тэмдэг бүхий 5-аас доош насны хүүхэдтэй бүх ажилтанд 5 өдрийн цалинтай чөлөө олгохыг төрийн бүх байгууллагад үүрэг болгожээ. Түүнчлэн Засгийн газраас 18 хүртэлх насны хүүхдэд олгож буй Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, шаардлагатай өрхүүдэд хүнсний эрхийн бичиг түгээх, сар тутмын нийгмийн халамжийн тэтгэлгийн хэмжээг нэмэгдүүлэх зэргээр эдийн засгийг идэвхжүүлж, иргэдийн амьжиргааг дэмжсэн байна.

Хэдий дээрх хүчин чармайлтыг гаргасан ч цар тахлыг таслан зогсоох арга хэмжээнүүдээс үүдэн эмэгтэйчүүд голдуу бага насны хүүхэдтэй асран хамгаалагчдад хэт их ажлын ачааллын стресс, мөн ажилгүй, орлогогүй болох зэрэг хувийн болон эдийн засгийн их хэмжээний сөрөг нөлөөллийг үзүүлжээ. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа зогссоноос үүдэн Монгол Улсын нийт өрхийн 40 гаруй хувьд хүндрэл үүсэж, нийт өрхийн 34% нь хүүхэд харахтай холбоотой нэмэлт зардал гаргах шаардлагатай нүүр тулсан байна. 2020 оны 1 дүгээр сарын эцэс гэхэд Монгол Улсын нийт өрхийн 73% нь, үүний 85%-ийг бүрдүүлдэг ядуу өрхүүд, хүнсний бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх, ажилгүй болох, бизнесийн үйл ажиллагаагаа зогсоох зэрэг цар тахал болон түүнтэй холбоотой хязгаарлалтын арга хэмжээнээс үүдэн хүндрэлд оржээ. Түүнчлэн, нийт өрхийн 27%-д орлого нь буурсан болон хүнсний бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнээс шалтгаалан хүнсний хэрэглээгээ бууруулах шаардлагатай болсон байна.

Эдийн засагт үзүүлсэн бусад нөлөөллийн хувьд КОВИД-19 цар тахлаас үүдэн эмэгтэйчүүд түлхүү ажилладаг жижиг, дунд бизнесүүд, үйлчилгээний газруудын 50 илүү хувь нь үйл ажиллагаагаа зогсоон үүдээ барьсан байна. Эдийн засгийн зарим салбар хямралд илүүтэйгээр өртсөний тоонд ажиллах хүчийг нь үндсэндээ эмэгтэйчүүд бүрдүүлж байдаг аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбар оржээ. Монгол Улсад тулгарсан энэ хүндрэл нь байнгын хөдөлмөр эрхэлдэг болон жижиг, дунд бизнес эрхэлдэг эмэгтэйчүүдэд урт удаан хугацаанд үргэлжлэх санхүүгийн хүндрэл авчирч болзошгүй байна. Орлого огцом буурсан, огт орлогогүй болсон олон эмэгтэйчүүд санхүүгийн

хувьд нөхрөөсөө хараат болсон. Эмэгтэйчүүд өөрийн албан тушаал дэвших төлөвлөгөөгөө өөрчлөх, эсвэл хойшлуулахаас аргагүй байдалд хүрсэн бол зарим нь цар тахлаас эдийн засагт үзүүлж буй нөлөөллөөс үүдэн ажилдаа эргэн орох, албан тушаал дэвших боломж нь хаагджээ.

Цар тахлын улмаас сургуулиуд хаагдсанаар нийт өрхийн 40 орчим хувьд хүүхэд харах нэмэлт үүрэг хариуцлага оногджээ. Тэдэнд тулгарч буй ажлын ачааллыг бууруулах арга хэмжээг Засгийн газар авч хэрэгжүүлсэн ч эхчүүдийн ажлын ачаалал нэмэгдсэний зэрэгцээ ажлаас чөлөө авах, таслах зэргээс үүдэн ажилгүй болох эрсдэлд анхаарах шаардлага үүссэн байна.

Нөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүд хувийн болон гэр бүлийн түвшинд харилцан адилгүй нөлөөллийг мэдэрчээ. Ажлын цаг багассан, уян хатан горимд шилжсэн, хүүхэд харах, гэрийн ажил зэрэгт бусдаас дэмжлэг авах боломжтой болсноор зарим эмэгтэйчүүдийн гэр бүл, найз нөхдийн харилцаа сайжирсан байна. Бусад эмэгтэйчүүд сэтгэл санааны байдал болоод гэр бүл, найз нөхөдтэйгөө харилцах харилцаанд сөрөг нөлөөг мэдэрсэн нь орлого олохын тулд илүү цагаар ажиллах, гэрийн ажил ихэссэн, хүүхдийн хичээл хийлгэх зэрэг нэмэлт үүргээс хамааран чөлөөт цаг огцом буурсантай холбоотой гэжээ. Хөдөлмөр эрхэлдэг олон тооны эхчүүд ажил олгогчдын зүгээс дэмжлэг үзүүлэхээс татгалзсан, ажилчдаа дэмжих байдал, ойлголт дутмаг байсныг дурдсан.

Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүд, асран хамгаалагчдад цар тахлын үеэр тулгарсан асуудлууд нь цар тахлын ба цар тахлын дараа үед гэр бүлийн болон олон нийтийн дэмжлэгийн механизмыг цаашид сайжруулан хөгжүүлэх хэрэгцээг тодруулан гаргажээ. Судалгааны үр дүн нь бага төлбөр бүхий өдөр өнжүүлэх төв болон тухайн орчинд хүүхэд харах үйлчилгээ зэргийг нэмэгдүүлснээр хөдөлмөр эрхэлдэг эхчүүдэд ажлын цагаар хүүхдэдээ санаа зоволтгүй ажиллах боломжийг хангаж, туслах тогтолцоог бий болгох шаардлага байгааг тодруулсан байна. Засгийн газраас эхчүүд, тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн эдийн засаг, нийгмийн дэмжлэгийг хүргэхэд төвлөрөн ажиллах шаардлагатай буй ба үүнд төр эсвэл хувийн хэвшилд ажилладаг эсэх, нас, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, эрхэлж буй ажил, орлогын түвшин зэргийг харгалзан үзэх шаардлагатай. Онлайн хэлбэрээр, цахимаар хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүд мөн ажлын чадвараа сайжруулах, чадавх бэхжүүлэх чиглэлээр дэмжлэг авч, үүний үр өгөөжийг нь хүртэх шаардлагатай ба ялангуяа хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүйдэлд нэрвэгдэх өндөр эрсдэлтэй эмэгтэйчүүдэд энэ дэмжлэгийг үзүүлэх нь зөв. Чадавх бэхжүүлэх боломжуудад мэдээллийн шинэ технологи, зайнаас суралцах, мэдээлэл харилцаа холбоо, олон нийтийн сүлжээний маркетингийн ур чадвар олох зэрэг багтаж байна.

ТАНИЛЦУУЛГА

Энэхүү тайланд ажил хөдөлмөр эрхэлдэг, бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдэд КОВИД-19 цар тахлын үед тулгарсан асуудлуудыг судаллаа. Тайланд тусгасан үр дүн нь баримт бичгийн шинжилгээ, хувь хүмүүстэй хийсэн ярилцлагад үндэслэсэн болно. Судалгаа нь Монгол Улсад цар тахлын үеэр эмэгтэйчүүд ажил, амьдралаа зохицуулах боломжийг хангах зорилгоор авч хэрэгжүүлсэн нийгмийн халамжийн дэмжлэг бүхий төрөл бүрийн механизмууд; ажил эрхлэх нөхцөл нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, сайн сайхан байдал, ирээдүйн ажил мэргэжилдээ өсөн дэвших боломжуудад хэр хэмжээнд сөрөг нөлөө үзүүлсэн; цар тахлын эсрэг Засгийн газрын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэргийг судлан үзсэн. Хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагаар цар тахал нь тэдний ажлын ачааллыг нэмэгдүүлж, уян хатан ажиллах цагийн сонголт хомсодсон, гэрээсээ ажиллахад шаардлагатай нөөц эх үүсвэрүүд дутагдалтай, үүнд интернэт болон технологийн хүртээмж хязгаарлагдмал байсан зэргээс үүдэн тэдний ажил эрхлэлт, санхүүгийн байдалд ихээхэн сөрөг нөлөөг үзүүлснийг олж тогтоосон.

Судалгааны ерөнхий асуултууд

Энэхүү судалгааны гол зорилго нь хөдөлмөр эрхэлдэг хүүхэдтэй эмэгтэйчүүдэд КОВИД-19 цар тахлын үзүүлсэн нийгэм-эдийн засгийн нөлөөллийг тодорхойлох явдал байсан. Судалгааны хүрээнд (1) нийгмийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээний үр дүнтэй байдал, (2) уян хатан ажиллах нөхцөлийн хамрах хүрээ, үр дүнтэй байдал, болон (3) Засгийн газраас цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний үр дүнтэй байдлыг судалж үзлээ. Анхдагч шатанд хийсэн баримт бичгийн судалгаанд үндэслэн судлаачдын зүгээс судалгааны ерөнхий гурван асуултыг тодорхойлон гаргасан:

1. Нийгмийн дэмжлэгийн арга механизм, ажлын уян хатан нөхцөл, төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зэрэг нь КОВИД-19 цар тахлын үеэр ажил хөдөлмөр эрхлэх эмэгтэйчүүдийн боломжид хэр хэмжээнд нөлөөлсөн бэ?
2. Цар тахлаас эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлсэн нөлөөлөл нь тэдний сайн сайхан байдал, ажил мэргэжлээр ахиж, дэвших боломжид хэр сөрөг нөлөөлөл үзүүлсэн бэ?
3. Цар тахал нь өрх дэх эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах үүрэгт хэр хэмжээнд сөрөг нөлөөлсөн бэ?

Судалгааны баг нь баримт бичгийн судалгааг 2020 оны 10 болон 11 дүгээр саруудад хийж гүйцэтгэсэн.

Судалгааны багийн зүгээс онлайн хэлбэрээр болон утсаар нийт 16 удаагийн чанарын мэдээлэл цуглуулах хагас бүтэцлэгдсэн ч ярилцлагыг 2021 оны 1-2 сард

нийслэл Улаанбаатар хотод төр, хувийн хэвшилд ажилладаг эмэгтэйчүүдтэй хийсэн. Энэхүү судалгааны үр дүнг доор тусган харуулсны зэрэгцээ Хавсралт хэсэг дээр судалгааны арга зүйг дэлгэрэнгүй тайлбарлав.


5C: КОВИД-19 цар тахлаас (Covid-19) хотуудын (Cities), нөхцөл байдал (Context), капитал (Capital) болон чадамжид (Capabilities) үзүүлсэн нөлөөлөл

Судалгааны суурь үзэл баримтлалыг Азийн Сан болон Кор Глобал (Core Global) зөвлөх компани боловсруулсан болно. ¹ Энэхүү 5Cs үзэл баримтлал нь КОВИД-19 цар тахлаас хотуудын нөхцөл байдал, капитал болон чадамжид үзүүлсэн нөлөөллийг гурван гол чиглэлд судлан үзсэн. Үүнд, нэгдүгээрт КОВИД-19 цар тахлын эрүүл мэндийн бус нөлөөлөл, Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хязгаарлалтын арга хэмжээний үр дагаврыг; Хоёрдугаарт бид иргэдийн капитал хөрөнгө (биет болон биет бус), ялангуяа санхүүгийн, нийгмийн болон боловсролын (хүний) капиталд цар тахал болон хязгаарлалтын арга хэмжээ хэрхэн нөлөөлснийг; Гуравдугаарт хүмүүсийн хадгалж байсан нөөц дундарснаас үүдэн тэдний богино болон урт хугацаанд хүндрэлийг даван туулах чадварт нөлөөлж, улмаар ирээдүйн чадамж, ялангуяа ажил эрхлэлтээ баталгаажуулах, албан тушаал дэвших, гэрээс гадуурх хараат бус байдлаа сайжруулахад нь сөргөөр нөлөөлсөн талаар судлан шинжилсэн юм. Дүн шинжилгээний эдгээр гурван түвшин болох нөхцөл байдал, капитал болон чадамж хоорондын уялдаа

холбоо нь энгийн ч бус, шугаман ч бус, нөхцөл байдал нь капитал болон чадамжид нөлөөлөх хандлагатай бол капитал болон чадамж нь нөхцөл байдалд гарч буй өөрчлөлтийг төрөл бүрийн хувь хүн, бүлгүүд хэрхэн хүлээн авч буйгаас хамааралтай байв.

Энэхүү тайланд бүтцийн хувьд эхний хэсэгт Монгол Улсад үүссэн цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан эрүүл мэндийн бус нөлөөллийг багтаасан болно. Хоёрдугаар хэсэгт цар тахлыг тогтоон барих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнээс судалгааны субъектүүд, тэдний гэр бүлийн санхүүгийн байдалд үзүүлсэн

нөлөөллийг хэмжин судалсан. Гуравдугаар хэсэгт хөл хорио болоод нийгмийн дэмжих үйлчилгээ хомс байснаас үүдэн хүн, нийгмийн капиталд учруулсан хор хохирлын талаар судалсан. Дараагийн хэсэгт эмэгтэйчүүдийн чадамжид үзүүлж буй ирээдүйн боломж, эргэн сэргэлтэд нь сөргөөр нөлөөлөхүйц, урт хугацааны нөлөөг судлахын тулд анхдагч нөлөөллийг судалсан. Сүүлийн хэсэгт судалгааны үр дүнгээр тогтоосон бодлогын нөлөөллийг судлан, бодлого боловсруулагчид болон хөгжлийн түншлэгч байгууллагуудад хандсан багц зөвлөмжийг багтаасан болно.



1. НӨХЦӨЛ БАЙДАЛ: КОВИД-19 ЦАР ТАХЛЫГ ХЯЗГААРЛАХ АЛХМУУД

Монгол Улс нь шинэ коронавируст (КОВИД-19) халдварын цар тахлаас хэд хэдэн сөрөг нөлөөллийг мэдэрсэн байна. Цар тахлын эсрэг хариу арга хэмжээний 2020 оны эхэнд Монгол улс “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт” шилжиж, үүний хүрээнд цар тахлыг тогтоон барих хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлсэн.² Жишээ нь 1 дүгээр сарын эцэст Улсын онцгой комиссын (УОК) шийдвэрээр БНХАУ-тай хиллэдэг хилийг хаасан.³ Мөн 1 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн боловсрол, сургалтын бүх байгууллагын үйл ажиллагааг зогсоож, 04 дүгээр сарын 30-ны өдөр эргэн нээхээр төлөвлөсөн байна.⁴ Ийнхүү боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг зогсоосноор бага, дунд, ахлах сургуулийн хөтөлбөрийг онлайн горимд шилжүүлж, улмаар Засгийн газар 139 тоот тогтоол гарган сургуулиудын үйл ажиллагааг зогсоосон хугацааг сунгаж, радио, телевизээр явуулах хичээлийн хугацааг 2020 оны 06 дугаар сарын 01-нийг хүртэл сунгажээ.⁵ Мөн Засгийн газрын 30 дугаар тогтоолоор “Амьсгалын замын хурц өвчтэй, томуу болон томуу төст өвчнөөр өвчилсөн 5 хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүд, асран хамгаалагч нар 5 хүртэл хоногийн цалинтай чөлөө олгохыг” бүх төрийн байгууллагад үүрэг болгосон. Нийслэлийн Засаг даргын зүгээс КОВИД-19 цар тахлын тархалтыг бууруулах зорилгоор хэд хэдэн тушаал шийдвэр гаргасан ба үүний нэг нь нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бүх сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосон 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/268 дугаар тушаал багтаж байна. Эдгээр хязгаарлалтын арга хэмжээний заримыг цуцалж, 2020 оны 05 дугаар сараас дээд боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг эргэн нээсэн ч 16-аас доош насны хүүхдүүд суралцаж буй дунд сургуулийн үйл ажиллагаа хаалттай хэвээр байжээ.

Сургуулийн үйл ажиллагааг зогсоосноос үүдэн хөдөлмөр эрхэлж буй эцэг эхчүүд, асран хамгаалагчид бага насны хүүхдээ асран хамгаалах хүнгүйгээр гэртээ үлдээх эрсдэлийг бууруулахын тулд Нийслэлийн Засаг дарга 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдөр А/268 тоот тогтоол гаргасан ба үүнд “Нийслэлийн харьяа байгууллагуудад ажиллаж буй 12-оос доош насны хүүхэдтэй эхчүүдийн ажлын цагийг цалинг нь бууруулалгүйгээр 1 цагаар хорогдуулахаар” заасан. Түүнчлэн Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/436 дугаар тушаалд гэртээ харгалзах хүнгүй үлдэж буй хүүхдүүдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулж ажиллахаар заажээ. 2020 оны 02 дугаар сарын 29-ны өдөр Засгийн газраас өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг 2020 оны 07 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл сунгасан байна.

2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр УИХ-аас гаргасан 167 тоот тогтоолд КОВИД-19 цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгасан. Энэ тогтоолоор 04 дүгээр сарын

01-нээс 10 дугаар сарын 01-ний хооронд 0-18 насны бүх хүүхдэд олгох хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг 70,000 төгрөгөөс 100,000 (ойролцоогоор 23.2 ам.доллаароос 33.2 ам.доллар хүртэл) хүртэл нэмэгдүүлэх; 05 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 01-нийг хүртэл хугацаанд хэрэгцээтэй өрхүүдэд хүнсний эрхийг бичиг олгох; болон Нийгмийн халамжийн сангаас олгох сар тутмын тэтгэврийг 05 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 01-ний өдрийн хооронд 188,000 төгрөгөөс 288,000 төгрөг хүртэл нэмэгдүүлж (62.4 ам.доллаароос 95.6 ам.доллар) олгохоор заасан байна.

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ НЬ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЭХЧҮҮДЭД СӨРӨГ НӨЛӨӨ ҮЗҮҮЛСЭН

Цар тахлыг тогтоон барих арга хэмжээ, сургуулийн үйл ажиллагааг зогсоосон болон хэрэгжүүлсэн бусад бодлогын арга хэмжээ нь хөдөлмөр эрхэлдэг, бага

насны хүүхэдтэй эмэгтэйчүүдэд онцгой сөрөг нөлөө үзүүлжээ. Монгол Улсын иргэд олон нийтийн арга хэмжээнд оролцохгүй, зай барих журмыг баримтлах замаар төрөөс гаргасан шийдвэрийг даган мөрдсөн байна.⁶ Гэвч бага, дунд сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосон нь сургуулийн насны хүүхэдтэй хүмүүст илүү хүндээр тусаж, нийт өрхийн 40 гаруй хувь нь сургууль хааснаас үүдэн төрөл бүрийн асуудалтай нүүр тулгарсан байна.⁷ НҮБХХ-ийн судалгаагаар сургууль хаагдсанаас үүдэн өрхүүдийн 41.6% хүүхдээ гэртээ өөрсдөө харсан бол 34% нь хүүхэд харахад зориулан нэмэлт зардал гаргасныг тогтоожээ.

Сургуулиудын үйл ажиллагааг түр зогсоосноор хүүхэд асрахтай холбоотой үүрэг хариуцлагыг, жишээ нь гэрт нь харах, хоол хүнс бэлтгэх зэрэг ажлыг улам нэмэгдүүлжээ.⁸ Засгийн газрын зүгээс ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийг ажлаасаа нэг цагийн өмнө тарах боломжийг олгон ачааллыг нь бууруулах арга хэмжээ авсан ч энэ нь нөгөө талаар хүүхэд асрах нэмэлт ажил үүргийг бий болгосон бөгөөд олон эмэгтэйчүүд хүүхдээ харахын тулд ажиллах цагаа багасгах шаардлагатай болж, улмаар орлого нь буурсан байна.⁹

Монгол уламжлалаар хүмүүс гэр бүлийнхний дэмжлэг туслалцаанаас ихээхэн хамааралтай байдаг ба цөөн ам бүлтэй өрхийн хувьд энэ тусламж дэмжлэг бага байдаг. Өрх толгойлсон эхчүүдийн хувьд хүүхэд асрах нь хамгийн өндөр ачаалалтай үүрэг байх ба цар тахлаас үүдэн энэ байдал улам нэмэгджээ.¹⁰ КОВИД-19 цар тахлын үеэр гадуур ажлаа хийж байсан зарим эмэгтэйчүүдийн хувьд хүүхэд харах, гэрийн ажил зэргийг өөрийн эцэг эх, бусад хамаатнууддаа найдаж үлдээжээ. Гэвч олон эмэгтэйчүүдийн хувьд бага насны хүүхдийг нь эцэг, эх нь, ялангуяа эмээ нар нь харж өгдөг ч КОВИД-19 цар тахал нь өндөр настнуудад өндөр эрсдэлтэй тул үр хүүхдүүддээ тусламж, дэмжлэг үзүүлэх нь багассан байна. Үүний улмаас нийт өрхийн 12.7% нь хүүхдээ гэрт нь харгалзах хүнгүй орхих, эсвэл мөн бага насны ах, эгч нарт нь найдан үлдээж байсан хүүхэд ахуйн осолд өртөх эрсдэлийг нэмэгдүүлжээ.¹¹ Өндөр настай, эрсдэлтэй бүлэгт хамаарах, жишээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг гэрт нь ямар ч хараа хяналтгүй үлдээх тохиолдол гарч байжээ.

Цар тахал, хөл хорио нь санхүүгийн хувьд томоохон хүндрэл бэрхшээлийг учруулсан. Бизнес эрхлэгчид үйл

ажиллагаагаа зогсоосноос үүдэн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд ажилгүй болжээ. Эдийн засгийн зогсонги байдал, зорчих хөдөлгөөний хязгаарлалт нь үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын аль алинд нь сөргөөр нөлөөлсөн.¹² 2020 онд нийт аж ахуйн нэгжийн 75% нь хэрэглэгчид, борлуулалтынхаа 50 хүртэл хувийг алджээ. Түүнчлэн КОВИД-19 цар тахал нь зардал огцом өсөх, хөрөнгө оруулалт хийх боломжоо алдах, зээлээ эргэн төлөх чадваргүй болох, ажлаас халагдах, бараа, материал импортоор оруулж ирэх боломж хаагдах, гэрээний үүргийг биелэлт тасалдах зэрэг олон эрсдэлийг учруулжээ.¹³

2020 оны 1 дүгээр сарын эцэс гэхэд Монгол Улсын нийт өрхийн 75%, үүний 85% болох орлого багатай ядуу өрхүүд, цар тахал, хорионоос үүдсэн ямар нэгэн хэлбэрийн эдийн засгийн хүндрэлтэй тулгарсны тоонд хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт, ажилгүйдэл, бизнесийн үйл ажиллагаагаа зогсоох зэрэг багтсан байна.¹⁴ Хөл хорио тавих, ажлаас халах, бизнесийн үйл ажиллагаагаа зогсоох болон бусад нөлөөллийн улмаас бүтэн цагаар хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн 19% нь 2020 оны 5 дугаар сарын эцсийн байдлаар ажилгүй болжээ. Түүнчлэн хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн 16% нь ямар ч орлого олоогүй бол 73% нь орлого нь буурсан хэмээн үзжээ.¹⁵ НҮБХХ-ийн хийсэн судалгаагаар айл өрхүүдийн 27% нь өрхийн орлого буурсан, мах, гурил, сүүн бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнээс шалтгаалан өмнөхөөс бага хоол хүнс хэрэглэх болжээ. Нийт өрхийн дөнгөж 2% нь л томоохон дэгдэлт үүсэх нөхцөлд ашиглах хүнсний нөөцтэй байжээ. Эдгээр өрхөөс ихэнх нь гурван долоо хоног хүрэхгүй хэмжээний хүнсний нөөцтэй байна.¹⁶ Цэцэрлэг, сургууль хаагдсанаас үүдэн сургуулийн өмнөх насны болон бага ангийн хүүхэдтэй өрхүүд Ковидын өмнөх үетэй харьцуулбал хүнсэнд илүү их мөнгө зарцуулж, хүүхдүүд сургууль дээрээ бус гэртээ хооллох болсноор өрхийн хүнсний хэрэглээ 8.6%-иар буюу 5.4 мянган төгрөгөөр нэмэгджээ. Төрөөс үзүүлсэн дэмжлэг хангалтгүй байсан, хэмжээ буурснаас үүдэн энэхүү нэмэлт зардал нь бага орлоготой өрхүүдэд илүү хүнд туссан байна.¹⁷

КОВИД-19 цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлсэн бодлого нь олон иргэдийн хувьд амжилттай хэрэгжсэн гэж үзэж байна.

Хувиараа хөдөлмөр эрхэлдэг 120,000 иргэн нийгмийн даатгалаас тэтгэлэг авч, 1,250,000 хүүхэд сар тутамд Хүүхдийн мөнгөн тэтгэлэг болох 100,000 төгрөг (ойролцоогоор 35 ам.доллар) авчээ.¹⁸ Гэвч Засгийн газраас үзүүлсэн дэмжлэгт дутагдалтай хоёр зүйл буй нь: (1) үндэсний хэмжээний шийдвэр гаргагчид, хууль сахиулах байгууллагуудын авсан арга хэмжээ, түгээсэн

мэдээлэл нь зөрүүтэй байсан, (2) албан бус салбарыг дэмжих бодлого дутмаг байсан асуудлууд байна.¹⁹ Түүнчлэн хөдөлмөр эрхлэх боломж, эдийн засгийн эмзэг байдлын хувьд эмэгтэйчүүд, ялангуяа жижиг бизнесийн салбарт ажилладаг эмэгтэйчүүдийн хувьд үйл ойшоох, орхигдох нөхцөл байдлыг ихээр мэдэрчээ.²⁰



Монгол улс, Улаанбаатар хот.
Эх сурвалж: Flickr

2. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЗҮГЭЭС ГЭР БҮЛДЭЭ ТУС ДЭМ БОЛОХ БОЛОМЖ БУУРСАН НЬ САНХҮҮГИЙН КАПИТАЛЫН ХОМСДОЛД ХҮРГЭСЭН

КОВИД-19 цар тахлаас үзүүлсэн эдийн засгийн сөрөг нөлөө нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, ЖДҮ-үүдэд ажилладаг эмэгтэйчүүдэд илүү хүндээр тусжээ.²¹ Эмэгтэйчүүдийн ажиллуулдаг ЖДҮ-үүд нь цар тахал гарахаас ч өмнө бүтцийн хувьд эмзэгт тооцогдож байв. НҮБХХ, АХБ болон Жендерийн үндэсний хорооны гаргасан тайланд “Эмэгтэйчүүдийн ажиллуулж буй ЖДҮ-үүдэд зориулсан техникийн туслалцаа, бизнесийн ашигтай төлөвлөлт, загварчлалын талаарх зөвлөх үйлчилгээ дутмаг байна” гэж дүгнэжээ.²² Тиймээс ч цар тахлын үеийн хязгаарлалтуудаас үүдэн эмэгтэйчүүдийн эрхэлж буй ЖДҮ, үйлчилгээний газруудын 50 гаруй хувь нь хаалгаа барьсан нь гэнэтийн зүйл бус юм. Үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлсэн ЖДҮ-үүд, төр болон хувийн байгууллагууд ч халдвар хамгаалал, ариун цэвэр зай барих шаардлагаас үүдэн ажилтнуудынхаа ачааллыг нэмэгдүүлж, илүү цагийн цалин хөлсний зардал нь нэмэгджээ.

Түүнчлэн НҮБХХ болон бусад байгууллагуудын бэлтгэсэн тайланд дурдсанаар нийт ажиллагсдынх нь 80.2% нь эмэгтэйчүүдээс бүрддэг боловсрол болон бусад салбарт цар тахлаас үүдэлтэй хязгаарлалтын арга хэмжээ нь илүү өндөр, ялгаатай сөрөг нөлөөллийг үзүүлснийг дурджээ. Багш нар л гэхэд зайнаас онлайн хичээл заахын тулд гар утас, интернэт болон бусад тоног төхөөрөмжийг худалдан авах шаардлагатай болжээ.²³ Олон тооны эмэгтэй бага цалинтай, эрсдэл өндөртэй нөхцөлд ажил эрхэлж байна. Цар тахлын үед тэдэнд нэмэлт үүрэгт ажил нэмэгдсэн нь ажлын үндсэн цаг дууссаны дараа хийх КОВИД-19 халдварын талаарх онлайн сургалт зэрэг байна. Энэ байдал нь тэдний нуруун дээр буй ажлын өндөр ачааллыг улам нэмэгдүүлжээ.²⁴ 2020 оны 1-12 дугаар сард ажилгүй болсон гурван хүн тутмын хоёр нь цар тахалд хамгийн ихээр өртсөн салбарууд, жишээ нь аялал жуулчлалын салбарт ажиллаж байсан ба энэ салбар гадаад болон дотоод аялал жуулчлалд тавьсан урт хугацааны хязгаарлалтад хамгийн ихээр өртсөн болохыг харуулж байна.²⁵ Хөнгөн үйлдвэр, зочид буудал, нийтийн хоол, аялал жуулчлалын салбарт ажлын байр цомхотгох шийдвэр нь эрэгтэйчүүдээс

илүүтэй эмэгтэйчүүдэд илүү хүнд тусаж, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог бууруулж, ажлын байр бий болгох, эргэн сэргэх боломжийг удаашруулсан.²⁶

Үндсэндээ эмэгтэйчүүд, асран хамгаалагч нарт тулгарсан цалингүй ажлын нэмэлт ачаалал (жишээ нь гэрийн ажил) нь тэдний орлого, сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн байна. Орлого багатай, олон хүнтэй өрхийн эмэгтэйчүүдийн хувьд эрсдэлд онцгойлон өртжээ.²⁷

Зарим аж ахуйн нэгж ажлын цаг богиносгох, уян хатан нөхцөл санал болгох зэргээр дэмжлэг туслалцаа үзүүлжээ. Хөл хорионы үеэр аж ахуйн нэгжүүдийн 50 орчим хувь нь 8 цагийн ажлын өдрөө бууруулсан бол гуравны нэг орчим нь өөрийн ажилчдад зайнаас ажиллах боломж олгожээ. Уян хатан нөхцөл санал болгосон компаниуд, ажил эрхлэгч 4 эмэгтэй тутмын 1 нь богиносгосон цагаар гэрээсээ ажиллах боломжтой байжээ.²⁸ Нөгөө талаар ажлын богино цаг нь хоёр үзүүртэй илд мэт байсан ба эхчүүд гэртээ түлхүү байх нь тухайн цагийн цалин тооцогдохгүй, гэрийн ажилд нэмэлт ачаалал авах болжээ.

ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮР АШИГ МУУТАЙ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

Монгол улсын Засгийн газрын зүгээс цар тахлын эдийн засгийн нөлөөллийг бууруулах зорилгоор татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн ч ихэнх төрийн албан хаагчид энэ дэмжлэгт хамрагдаагүй байна.

Бид нийгмийн даатгалын шимтгэл, татвараас чөлөөлөгдөөгүй. Төрөөс цалин авдаг учир ямар нэгэн хөнгөлөлт, чөлөөлөлтөд биднийг хамруулаагүй. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалыг төр хариуцан төлдөг учир бидэнд ямар ч өөрчлөлт гараагүй.”

(Улсын бүртгэлийн ажилтан эмэгтэй)

Ажиллаж буй байгууллагын төрлөөс хамааран,²⁹ судалгаанд хамрагдсан хоёр төрийн албан хаагч татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн нь цар тахлын үед тэдэнд ихээхэн дэм болжээ. Ярилцлагад хамрагдсан хувийн хэвшлийн төлөөллийн хэлснээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь тэдний өрхийн санхүүгийн байдалд эергээр нөлөөлжээ.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүд, тэдний гэр бүлд Хүүхдийн мөнгөн тусламж санхүүгийн хувьд томоохон дэмжлэг болжээ. Цар тахлын үеэр ажлаа хийж байсан төр, хувийн хэвшлийн ажилчдын дийлэнх нь Хүүхдийн мөнгийг тэдний ирээдүйд зориулан хадгалдаг байна. Орлого, ажлын байргүй болсон эмэгтэйчүүдийн хувьд Хүүхдийн мөнгө нь өрхийн амьдралыг хэвийн авч явахад түлхэц болж, хоол хүнс худалдан авах, хүүхдийн сургалт, сонирхолтой холбоотой төлбөрт зарцуулагджээ.

“Бид өмнө нь 5 хүүхдийн 100,000 төгрөг авдаг байсан бол одоо сар бүр 500,000 төгрөг авдаг болсон. Ажлаасаа халагдсаны дараа Хүүхдийн мөнгөөр л хоол хүнсээ худалдан авч байсан”.

(Зочид буудлын ажилтан асан эмэгтэй)

“Миний бодлоор Хүүхдийн мөнгөний хэмжээг нэмэгдүүлсэн нь их зөв шийдвэр байсан. Хүүхдийн мөнгөө өрхийн суурь хэрэгцээндээ үрдэггүй эцэг, эхчүүдийн хувьд энэ мөнгийг ашиглан хүүхдээ хэрхэн хөгжүүлэх вэ гэж бодож эхэлсэн. Жишээ нь би энэ мөнгийг хүүхдийнхээ шатрын сургалтад зарцуулсан.”

(Хувийн компанийн захирал асан эмэгтэй)

ЦАР ТАХЛААС ҮҮДСЭН САНХҮҮГИЙН ХҮЧТЭЙ СӨРӨГ НӨЛӨӨ

Ярилцлагад хамрагдсан ихэнх эмэгтэйчүүдэд цар тахлын улмаас санхүүгийн сөрөг нөлөө тодорхой хэмжээнд мэдрэгджээ. Гэвч нөлөөллийн цар хүрээ, ноцтой байдал зэрэг нь ярилцлагад хамрагдсан хүн бүрийн хувьд ялгаатай байв. Энэ тал дээр төрийн болон хувийн хэвшилд ажиллагсад хооронд эрс зөрүүтэй байдал байхгүй ч төрийн албан ажилладаг хүмүүсийн хувьд зардал нэмэгдсэн, бусад нэмэгдэл буурсан зэргийг түлхүү илэрхийлсэн. Эсрэгээр хувийн хэвшилд ажиллаж байсан эмэгтэйчүүдийн хувьд ажилгүй болсон эсвэл бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болсноос үүдэн орлого ихээр буурсан эсвэл огт орлого олоогүй байна.

Ярилцлагад оролцогчдын зүгээс шаардлагатай бус худалдан авалтуудаа багасгасан тухайгаа олонтоо дурдсан. Зарим тохиолдолд орлого буурснаас үүдэн зардлаа танах шаардлагатай болсон хэмээн тэдний зүгээс тайлбарласан ч цалингаа үргэлжлүүлэн авч байсан хүмүүс ч мөн зардлаа бууруулахын ач холбогдлыг энэ үед ойлгон мэдрэсэн болохоо илэрхийлж байв.

“Бид сар бүр нарийн ногоо худалдан авахаа больж оронд нь гурил, будаа зэрэг зайлшгүй шаардлагатай зүйлсээ л авах болсон. Хувцас, хобби зэрэгт нэмэлт зардал гаргахаа зогсоосон. Өмнө нь номын дэлгүүрээс ном авдаг байсан бол одоо хуучин номоо худалдаж шинийг авах, эсвэл шинэ номоор бартерлаж байгаа... Өмнө нь дуртай гутал, хувцсыг нь хүүхдүүддээ

*худалдан авдаг байсан бол одоо “Та нарт ийм гутал, хувцас байгаа, тэрийгээ өмс” гэж хэлдэг болсон.”
(Хувийн хэвшилд ажилладаг эмэгтэй)*

Төрийн албанд ажилладаг зарим оролцогчид цар тахлын үеэр цалингаа авч байсан ч илүү цагийн мөнгө, хоол, унааны мөнгө зэрэг нэмэлт урамшуулал олгогдоогүй талаар хэлж байв.

“Санхүүгийн хүндрэлд орсон. Өмнө нь хуваариас гадуур илүү цагаар хичээл зааж, илүү цагийн хөлс авдаг байсан. Харин онлайнаар ажиллахад илүү цаг тооцогдохгүй учраас үндсэн цалингаа л авсан.”

(Дунд сургуулийн багш эмэгтэй)

Зарим эмэгтэйчүүдийн зүгээс нэмэлт зардал гарсан тухай дурдсан ба энэ нь ажлын зорилгоор утас, интернэт ашиглах нь нэмэгдсэн ч ажил олгогч нь нөхөн олгоогүйгээс үүджээ. Ялангуяа боловсролын салбарт ажиллагсдын хувьд онлайнаар хичээл заах болсон тул гар утасны датаны хэрэглээ нь ихээр нэмэгджээ.

“Миний утасны сарын төлбөр өмнө 30,000 төгрөг гардаг байсан. Харин Ковидын үед гэрээсээ байнга ажиллаж, эцэг эхчүүдтэй холбоо барьж байх шаардлагатай болсноор утасны төлбөр огцом нэмэгдсэн. (Цэцэрлэгийн багш эмэгтэй)

Бусад оролцогчид, ялангуяа хувийн хэвшлийн ажилтнуудын зүгээс санхүүгийн хүндрэлтэй холбоотой илүү хурц жишээг дурдсан. Үйл ажиллагаагаа бүрэн зогсоосон эсвэл ажлын цагаа ихээр хорогдуулсан хувийн компанийн эзэмшигчид, ажилчдад орлого буурах, ажилгүй болох асуудал тулгарсан. Тухайн эмэгтэйчүүдийн зарим нь санхүүгийн хувьд ноцтой хүндрэлд өртжээ. Өөрийн бизнесээ эхлүүлээд удаагүй байсан хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүд хүндрэлд хамгийн их өртсөн бүлэгт багтаж буй бөгөөд тэд салбарын туршлага бага, хөрвөх чадвар сул учраас илүү эмзэг, өртөмтгий байжээ.

“Ковидын эхний хөл хориог даван туулахын тулд гэр бүлдээ дэмжлэг үзүүлэх мөнгө байсан бол би бизнесээ тогтвортой үргэлжлүүлж, ажилчдынхаа цалинг тавьж, өрөө дарчихсан байх байсан... Эргэн төлөх шаардлагатай зээлтэй байсан ч ямар ч орлогогүй болж, хоол, хүнсэнд ч зарцуулах мөнгөгүй болсон. Миний оронд манай ээж л хамаг зардлыг гаргасан. Үндсэндээ бол манай ээж л намайг, манай гэр бүлийг тэжээж байна...”

(Бизнес эрхлэгч эмэгтэй)

Гэр бүлийн хүн нь ажилгүй болсон зарим оролцогчдын зүгээс өрхийн орлого огцом буурч, санхүүгийн дарамтад орсон тул ажил олгогчийн зүгээс ямар ч шаардлага тавьсан ажлаа үргэлжлүүлэн хийж байх шаардлагатай нүүр тулжээ.

“Манай нөхөр хувиараа хөдөлмөр эрхэлдэг байсан ч цар тахлаас үүдэн бизнес нь хаагдсан. Тухайн үед би эмийн санд ажиллаж байсан ч миний амьдралд өөрчлөлт гаргасан. Өөрөөр хэлбэл бүх хариуцлага (амьдралаа авч явах) над дээр буусан. Санхүүгийн хувьд хүнд байдалд орж, охиныхоо ирээдүйн талаар санаа их зовсон.”

(Эмийн сангийн ажилтан эмэгтэй)

Нөгөө талаар хувийн хэвшилд ажиллаж байгаад ажилгүй болсон зарим эмэгтэйн зүгээс нөхрөөсөө санхүүгийн хувьд хараат болсон талаар ярьж байв. Энэ бүлэгт цар тахлын нөлөөнд хамгийн их өртсөн, өөр ажил эрхлэх сонголтот боломж хязгаартай салбарууд болох аялал жуулчлал, үйлчилгээний салбарт ажиллаж байсан эмэгтэйчүүд багтжээ. Тэдний зарим нь зардлаа огцом бууруулах шаардлага үүссэн талаар ярьж байв. Түүнчлэн санхүүгийн хувьд нөхрийнхөө орлогоос хамааралтай болсон тул өмнө нь бие даан гаргадаг байсан санхүүгийн шийдвэрээ заавал нөхөртэйгөө зөвлөлдөж гаргах шаардлагатай болжээ.

“Ажилтай байхдаа би ямар нэгэн юм хийх, хаа нэг тийш явах гээд санаачилгатай байсан бол одоо тийм зүйл байхгүй болсон. Одоо бол зүгээр л юу хийх вэ гэсэн санал л гаргахаас өөр зүйл хийхээ больсон. Өмнө нь зун, намар хүүхдүүдээ аваад хаа нэг тийшээ явна гэж өөртөө төлөвлөдөг байсан бол одоо нөхөр зөвшөөрөх эсэхээс л хамааран ямар нэг зүйл хийдэг болоод байна.”

(Нислэгийн тийз борлуулах агентлагийн ажилтан асан эмэгтэй)



Суурин хөрөөгөөр мод хөрөөдөж буй эмэгтэй (Эх сурвалж: НҮБ ХХААБ-ын Ойн салбар, Flickr)

3. ХҮҮХЭД АСРАХ ЧИГЛЭЛЭЭР ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ТУЛГАРСАН ХАРИЛЦАН ЯЛГААТАЙ СОРИЛТУУД

Судалгаагаар төр, хувийн хэвшилд ажилладаг эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагаар цар тахлаас үүдэн ихэнх тохиолдолд тэдний ажлын ачаалал нэмэгдсэнийг тогтоосон. Төрийн албан хаагчид КОВИД-19 халдварын цар тахлыг зогсоохын тулд төрөөс авч хэрэгжүүлсэн олон нийтэд мэдээлэл хүргэх, судалгаа хийх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, хөл хорионы үед эргүүл, маск зүүх болон бусад арга хэмжээг сахиулахад оролцож байсан нь тэдний ажлын хэмжээг хэрхэн нэмэгдүүлж байсан талаар өгүүлж байв.

“КОВИД-19 цар тахал гараад л бид өдөр тутам ажиллах болсон. Өдөр шөнөгүй 24 цагаар ажилласан. Дуудсан тохиолдолд шууд гарахаар байнгын бэлэн байдалд байсан. 24 цаг ажилласны дараа жоохон амраад л эргээд бүтэн өдөр эргүүлд гардаг байсан. Өдөр нь гудамжаар эргүүл хийгээд дараа өдөр нь дахиад л 24 цаг ажиллаж байсан.”

(Төрийн албан хаагч эмэгтэй)

Ярилцлагад хамрагдсан их сургуулийн багш эмэгтэй онлайн ажилласан ч өөрийн болон оюутнуудын гүйцэтгэлийг өндөр байлгахын тулд өөрт ирсэн дарамтын талаар ярьсан. Онлайн хичээл заахтай холбоотой олон хүндрэл багш нарт тулгарсан ба үүнд интернэт холболтын асуудал, харилцаа холбооны олон сувгийн хооронд шилжин ажиллах зэрэг байжээ.

“Өмнө нь би цаг сайн барьдаг, ажлаа ч цагт нь дуусгадаг байсан нь өөрчлөгдсөн. Жишээ нь манай цэцэрлэгийг ПиСиАр шинжилгээ авах цэг болгож, онцгой байдлын үеэр төрийн албан хаагч тул утсаа унтрааж болохгүй, дуудсан цагт бэлэн байх хэрэгтэй байсан. Үүнээс болоод байнга бухимдалтай болж ... өмнө нь амраад, гэртээ байхдаа ажилладаггүй байсан ч одоо энэ боломж байхгүй болсон.” (Цэцэрлэгийн багш эмэгтэй)

Хувийн хэвшилд ажилладаг эмэгтэйчүүдийн хувьд цар тахлаас үүдэн компанийнх нь үйл ажиллагаа буурсан тул зарим нь ажлаас гарч, үүний улмаас үлдсэн хүмүүсийн ачаалал нь нэмэгджээ. Нэмэлт ажил хийхгүй бол ажилгүй болох байх хэмээн эмээж байсан талаар зарим оролцогчид дурдсан.

“КОВИД-19 халдвар тархаж эхлэхэд л зочид ирэхээ больж, манай компани үйл ажиллагаагаа хумьж эхэлсэн... Ажлаа хийж үлдсэн хүмүүсийн хувьд ажлын ачаалал нь нэмэгдэж, өглөөнөөс орой хүртэл ажиллаад ч дуусгаж чадахгүйд хүрсэн... Ажиллах хүмүүсийн тоо буурснаар ажлын ачаалал ихэссэн. Байгууллагын удирдлагын зүгээс шахалт их ирж, удирдлагын зүгээс “Үүнийг хийхгүй бол хална шүү” л гэдэг байсан.”

(Зочид буудлын ажилтан эмэгтэй)

Төр болон хувийн хэвшлийг төлөөлсөн оролцогчдын олонх нь ажлын өндөр ачааллыг ажиллах олон хэлбэртэй (жишээ нь зайнаас ажиллах) хослуулах шаардлагатай нүүр тулжээ. Хамтран ажилладаг хүмүүс нь өвдсөн эсвэл чөлөө авсан үед тэдний ажлыг давхар хийх дарамттай зарим нь тулгарсан тухай ярьсан. Тэдний тайлбарлаж буйгаар энэхүү нэмэлт ажил үүргийг байгууллагын бүхий л шатанд, албан тушаалын зэрэг дэв харгалзахгүйгээр хуваарилж байжээ.

“Санаа зовох олон асуудал байсны тоонд гэрээнд хэрхэн гарын үсэг зурах, гэрээсээ яаж тамга дарах, оффисын түрээсийн зардлаа яаж бууруулах, урт хугацааны зээлийн асуудлыг хэрхэн шийдэх гээд олон асуудал гарсан тул би хэдий захирал нь байсан ч гэсэн ажлын ачаалал нэмэгдсэн.”

(Хувийн компанийн Гүйцэтгэх захирал асан эмэгтэй)

УЯН ХАТАН БУС АЖЛЫН НӨХЦӨЛ НЬ ЭМЭГТЭЙЧҮҮД ЦАЛИНГАА БҮРЭН АВЧ ЧАДАХГҮЙД ХҮРГЭСЭН

Төрийн байгууллагад ажилладаг оролцогчдын хувьд зөвхөн нэг л оролцогч цар тахлын үед гэрээсээ ажиллах боломжтой байжээ. Бусад салбарт ажилладаг хэнд ч энэ боломж олдоогүй эсвэл боломжийг эрэлхийлэх хэрэгтэйгээ мэдээгүй ажээ.

“Тэд [бусад багш нар] бүгд сургуулийн захиргаанаас айж байсан. Бага насны хүүхэдтэй багш нар: “Бүү санаа зов. Ойрхон амьдардаг болохоор нэг хоёр өдрийг орлоод ажиллая” гэдэг байсан. Би ч зоригтой байх шаардлага үүссэн, учир нь манай гэр хол, ажилдаа ирэхийн тулд багадаа талдаа 1 цаг зарцуулдаг байсан.”

(Дунд сургуулийн багш эмэгтэй)

Ярилцлагад оролцсон зарим хүмүүс гэрээсээ ажиллах боломжтой талаар мэдэж байсан ч ажлын ачаалал нэмэгдсэнээр энэхүү боломжийг ашиглаж чадаагүй гэж үзжээ.

“Ямар ч дэмжлэг байхгүй, гэхдээ ажлаа хийхээс өөр ямар ч сонголт байгаагүй. 12 дугаар сард ажлын байран дээр олон хүний бөөгнөрөл үүсгэхгүйн тулд нийт ажилчдын 70% нь гэрээсээ, 30% нь оффис дээр ажиллахаар шийдсэн. Ажлын ачаалал их байсан тул энэ журмаа мөрдөж чадаагүй. Хийх ажил их байсан болохоор цар тахлын үеэр

ажлын цагийг багасгах боломж байгаагүй.”

(Төрийн албан хаагч эмэгтэй)

Хувийн хэвшилд удирдах албан тушаалд ажиллаж байсан нэг оролцогчийн зүгээс удирдлагын түвшинд тулгарсан зарим асуудлыг гарган ирсэн. Тэрээр өөрийн удирдлагад ажилладаг эмэгтэйчүүдэд уян хатан нөхцөл олгож, дэмжлэг үзүүлэхээр хичээсэн ч өөрт нь энэхүү боломж олдоогүй нь ажилтнууддаа уян хатан боломж олгохын зэрэгцээ удирдлагын ачаалал нэмэгдсэн, үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэх дарамт шахалт ихэссэнтэй холбоотой байжээ.

“Бид зарим ажилтандаа гэрээсээ ажиллах боломж олгохын зэрэгцээ долоо хоногт нэг өдөр ажиллах, ажлын цагийг нь өөрчлөх, ээлжээр ажиллах зэрэг хэд хэдэн сонголтыг нээж өгсөн. Тухайн нөхцөл байдлыг аль болох л уян хатан болгохоор хичээсэн. Нэг асуудал нь би гүйцэтгэх удирдлагад ажилладаг байсан тул өөрөө энэ боломжуудаа ашиглаж чадаагүй.”

(Хувийн компанийн захирал асан эмэгтэй)

Гэрээсээ ажиллах боломжтой эмэгтэйчүүдийн заримд нь ажил олгогч нь шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг гарган өгөөгүй ажээ.

“Интернэт байхгүй, гар утасны дата авах мөнгө байхгүй бол гэрээс ажиллах боломжгүй тул ажил дээрээ очихоос өөр сонголт байхгүй.”

(Их сургуулийн багш эмэгтэй).

Төр болон хувийн хэвшилд ажилладаг оролцогчид гэрийн орчноо ямар нэгэн ажил эрхлэхэд тохиромжгүй хэмээн үзжээ. Гэр бүлийн гишүүд, ялангуяа бага насны хүүхэд хамтдаа байх нь тэдний ажлын гүйцэтгэл, бүтээмжид нөлөөлдөг хэмээн хэлж байна.

“Гэртээ байхдаа ажилдаа төвлөрөх, юм бичихэд хэцүү. Гэрийнхэн унтсаны дараа өглөө болтол ажиллаж байгаад унтаж амардаг байсан. Тиймээс

онлайнаар ажиллахын зэрэгцээ миний хувьд үдээс хойш нь өглөө шиг, оройн 11 цаг үдээс хойшийн цаг шиг л байсан”.

(Судлаач эмэгтэй)

ГЭР БҮЛИЙН ОЙРЫН ГИШҮҮДИЙН ДЭМЖЛЭГ ЧУХАЛ ШААРДЛАГАТАЙ БАЙЖЭЭ

Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн хүүхэд харах ажлыг гэр бүлийн гишүүддээ л найдан үлдээх нь түгээмэл байна. Үүнээс хамааран зарим тохиолдолд бусдаас, хамгийн түгээмэл нь өндөр настан хамаатан саднаасаа бүрэн хамааралтай болж, хичээл хийлгэх зэрэг хүүхэдтэй холбоотой бүхий л зүйлсийг тэдэнд даатгажээ. Ярилцлагад оролцсон нэгэн эмэгтэй өөрийн охиныг хамаатныдаа амьдруулахаар явуулсан жишээ үүнд багтана. Бусад хүүхдийг нь эмээ өвөө нар нь өглөөнөөс орой хүртэл харж байжээ. Зарим тохиолдолд өндөр настай хамаатан садан нь гэр цэвэрлэх, хоол хийх зэрэг ажлыг хийж байжээ. Гэр бүлийн ойрын гишүүдээс үзүүлэх дэмжлэг туслалцаа нь цар тахлын үеэр эмэгтэйчүүд гадуур болон гэрийн ажлаа үргэлжлүүлэн хийх боломжийг хангахад чухал үүрэгтэй байжээ.

“Миний хувьд хүүхдээ гэрт нь үлдээхээс өөр сонголт байгаагүй. Хүүхэд маань эмээтэйгээ байдаг учраас би хүүхэдгүй хүн шиг л байсан. Эмээ нь байгаагүй бол их хүндрэлтэй нүүр тулах байсан”.

(Цагдаагийн ажилтан эмэгтэй)

Хувийн хэвшилд ажиллаж байсан зарим эмэгтэйчүүд мөн л гэр бүлийнхний дэмжлэгт найдаж байсан ч энэ нь төрийн албатай харьцуулбал арай бага байна. Бизнесийн үйл ажиллагаа зогссоны улмаас олон эмэгтэй ажилгүй болсон тул гэртээ хүүхдээ харсан эсвэл хүүхдээ харахын тулд ажлын цагаа зохицуулах боломжтой байжээ.

“Өөр ямар ч дэмжлэг туслалцаа байгаагүй ... [эмээ, өвөө нараас өөр] ийм байдлаар л би давж гарсан.”

(Гоо сайхны салоны ажилтан асан эмэгтэй)

Олон оролцогчийн зүгээс нэг эсвэл хоёр хамаатны хүнээсээ дэмжлэг туслалцаа авдаг талаар дурдсан. Нэг

эмэгтэй л олон хүнээс- өөрийн ээж, хадам ээж, нагац- зэрэг тусламж дэмжлэг авч байснаа хэлж байна. Энэ нь нийгмийн сүлжээ/ хэлхээ холбоо хязгаарлагдмал буйг харуулж буй юм. Нөгөө талаар ярилцлагад оролцогчид хүүхэд харах чиглэлээр бусад сонголт цөөн, бараг байхгүйг дурдсан. Жишээ нь нэгэн оролцогчийн зүгээс өндөр настай эцэг, эх нь хүүхдийг нь харж өгөх боломжгүй бол өөр хүн гуйхаас өөр аргагүй болсон талаар дурдсан.

Ярилцлагад оролцсон нэг оролцогчийн ярьснаар тэдний нийгмээс дэмжлэг авах хэвийн механизм нь цар тахлын үеэр улам доголдсон байна. Энэ байдал эмч эмэгтэйчүүдийн хувьд түлхүү тохиолдож байсан нь тухайн мэргэжлийнхэн КОВИД-19-ын халдвар тараах эрсдэлтэй хэмээн үзсэнээс нийгэм, олон нийт зайлсхийж байсантай холбоотой байна.

Цар тахлаас өмнө олон эмэгтэй хамаатан садныхаа ахмад насны хүмүүсээр хүүхдээ харуулдаг байсан ч цар тахал нь хүүхэд асрах сонголтууд хязгаарлагдмал байдаг асуудлыг улам тодруулан гаргасан байна. Хамаатнууд нь хүүхдийг нь харах боломжгүй болох тохиолдолд хөдөлмөр эрхэлдэг эхчүүд энэхүү асуудлыг хэрхэн шийдэж ирсэн нь тодорхойгүй байна.

4. ЧАДАМЖ: ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЧАДАМЖИД ХАНДСАН УРТ ХУГАЦААНЫ ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА ХЭРЭГЦЭЭТЭЙ БАЙНА

ТЭмэгтэйчүүдийн гэр бүлтэйгээ харилцах харилцаа, сэтгэл зүйн байдалд үзүүлсэн нөлөөлөл нь тухайн нөхцөл байдлаас хамааран ихээхэн ялгаатай байжээ. Олон тохиолдолд төр болон хувийн хэвшлийн ажилтнуудад тулгарсан эерэг, сөрөг зүйлсэд тодорхой ялгаа байхгүй. Харин ажлын ачаалал нэмэгдэх, уян хатан ажлын цаг, нийгмийн дэмжлэг зэрэг хувь хүмүүст үзүүлсэн нөлөөлөл харилцан ялгаатай байв.

Гэрээсээ ажилласан зарим эмэгтэйчүүдэд хөл хорио нь тэдэнд гэр бүлтэйгээ цагийг илүү үр бүтээлтэй өнгөрөөх боломж олгожээ. Хувийн бизнес эрхлэгч нэгэн эмэгтэйн зүгээс хүүхэдтэйгээ илүү их цаг өнгөрөөх, эрүүл мэнд, боловсролд нь илүү анхаарал хандуулах боломж бүрдсэнийг дурдсан. Гэвч тухайн оролцогч нь бусад эхчүүдтэй, тэр дундаа бизнес эрхлэгч эмэгтэйчүүдтэй харьцуулбал илүү азтай байснаа цохон дурдсан. Тэрээр хил хаахаас өмнө амжиж хэрэгцээтэй материалаа татан авсан байсан тул бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлжээ. Мөн ажилтнууд нь сайн сургагдсан, сошиал сүлжээ ашиглан бараа, үйлчилгээгээ сурталчлахыг сайн мэддэг тул цар тахлын үеэр борлуулалт нь нэмэгдэж, уян хатан ажиллах боломжтой байжээ.

Бусад оролцогчид гэртээ байх хугацаанд нь тулгарсан ижил төстэй эерэг байдлын талаар дурдсан. Зарим тохиолдолд цар тахлын үеэр гэр бүл нь илүү ойр дотно байх боломжтой байжээ. Мөн зарим эмэгтэйчүүд хөл хорионы үеэр хамтрагчийнхаа хамт илүү их цаг хамт өнгөрөөжээ.

*“Манай гэр бүл илүү ойр дотно болж, хамтдаа илүү их цаг өнгөрөөх болсон. Өмнө нь бид ажил ихтэй, бие биетэйгээ уулзах ч завгүй байдаг тул энэ нь эерэг мэдрэмж төрүүлсэн.”
(Их сургуулийн багш эмэгтэй)*

“Нэгдүгээр ангийн хүүхдэдээ хичээлийг нь өөрөө заах боломж гарсан. КОВИД-19 цар тахлаас өмнө бид бие биесээ сайн ойлгох хангалттай цагийг хамт өнгөрөөж байгаагүй. Харин одоо бий хүүхдийнхээ нөхцөл байдлыг илүү сайн ойлгож, өдөрт нэг цаг хамтдаа тоглож байхыг хичээх болсон. Хүүхдээ илүү сайн ойлгох давуу талтай болсон.”

(Төрийн албан хаагч эмэгтэй)

Бусад оролцогчдын зүгээс ч цар тахлаас үүдэн гэр бүлтэйгээ хамт байх нь багассан, стресс, ядаргаанд ихээр өртсөн байна. Ажлын ачаалал нэмэгдсэн оролцогчдын хувьд хүүхэд асрах арга зам хайх шаардлага үүссэн нь ажлын бүтээмжийг нь бууруулсан ба энэ байдал төрийн албан хаагчид дээр түлхүү үүссэн байна. Эдний эмэгтэйчүүдийн мэдэрсэн энэхүү дарамт нь цалинтай болон цалингүй ажил хийх, хүүхэд харах, гэрээр хичээл хийхийг зохицуулах, хамаатан саднаасаа тусламж хүсэхдээ өөрийгөө буруутгах зэрэг нөхцөл байдлаас улбаалан үүсжээ.

Төрийн албан хаагч нэг оролцогчийн зүгээс ажил болон охиныхоо гэрээр хийх хичээлийн тэнцвэрийг хангахад стресст орсон талаар ярьсан. Эмчийн ажилтай өөр нэгэн оролцогч уртасгасан цагаар ажиллах, охинтойгоо гэртээ байх боломжгүй байх нь стресст оруулж, энэ нь охинд нь сөргөөр нөлөөлсөн тухай дурдсан. Хүүхэдтэйгээ цагийг хамт өнгөрөөж

чадаагүй оролцогчдын хувьд онлайн хичээлд хүүхдүүд хангалттай хамрагдахгүй, хүүхдийн дүн буурсан, клуб болон нийгмийн чиглэлийн ажлууд зогссонтой холбоотой санаа зовних зүйл их байжээ.

СТРЕСС, ГЭМШИЛ, ТУСГААРДАЛ БОЛОН АЖИЛ ОЛГОГЧДЫН ОЙЛГОЛТ ДУТМАГ БАЙДАЛ

Зарим тохиолдолд эмэгтэйчүүдийн мэдэрсэн стресс, гэмшил зэрэг дээр нийгэм, олон нийтийн зүгээс шүүмжлэлтэй хандсан нь улам нэрмээс болжээ. Энэ явдал төрийн албанд ажиллаж буй эмэгтэйчүүдэд илүү тохиожээ. Нэгэн эмэгтэйн хэлснээр бусад хүмүүсийн зүгээс цалин багатай байж цар тахлын үеэр ажиллах нь зөв эсэхийг асууж байсан ч нөхөр нь яагаад ажиллаж байгааг хэн ч асуугаагүй байна. Харин хувийн хэвшилд ажилладаг эмэгтэйчүүдийн хувьд шүүмжлэлт байдалтай арай бага нүүр тулсан нь ажил, гэрийн ажлаа зохицуулах боломж эсвэл гэр бүлдээ анхаарал хандуулахын тулд ажлаасаа гарахаас өөр сонголтгүй болсонтой холбоотой.

Төр болон хувийн хэвшлийг төлөөлөн ярилцлагад хамрагдсан хүмүүс ажил олгогчдын зүгээс ойлголт, дэмжлэг хомс байсныг дурдсан. Төрийн албан хаагч нэг оролцогчийн хэлснээр ажил эрхэлж буй эцэг, эхэд ирдэг дарамтыг ойлгодоггүй ажил олгогчтой байх нь сөрөг нөлөөлж байжээ. Ажилдаа бүрэн хэмжээнд анхаарал хандуулж буйгаа харуулж “чадахгүй” бол сахилгын арга хэмжээ авхуулах байнгын дарамтад байдаг талаар төрийн албан хаагч нэгэн эмэгтэй дараах байдлаар тайлбарлаж байв. Түүний хэлснээр цар тахлын үеэр өөрийн эрхэлж буй төрийн ажилд “зүтгэж” буйгаа харуулахын тулд ажлын цагаар ажил дээрээ байх ёстой ажээ. Үүнээс үүдэн хүүхэд харах ажлаа ээждээ бүрэн даатгаж, хүүхэдтэйгээ хамаагүй бага цагийг хамт өнгөрөөх болжээ. Багшаар ажилладаг өөр нэгэн оролцогчийн зүгээс өөрийн сурагчдын онлайн сургалт болон гэрээсээ хичээллэж буй өөрийн хүүхдэдээ туслах хоёрын алинд нь анхаарал хандуулахаа эрэмбэлэхэд зөрчил үүсэж байсан талаар дурдсан.

Цар тахлын үеийн хязгаарлалтын арга хэмжээнээс улбаалан оролцогчид найз нөхөд, гэр бүлээсээ тусгаарлагдах шаардлага гарсны учир нь гэрээсээ

гадуур ажиллаж буй тэднийг КОВИД-19 халдвар дамжуулагч хэмээн үзэж байсантай холбоотой байна.

“Би бараг л өрөөндөө тусгаарлагдсан. Намайг гэртээ ирэхэд халдвар авсан байж болзошгүй гэж манай аав хана, хаалгаа спиртээр ариутгасан”.
(Эмч эмэгтэй)

Бусад эмэгтэйчүүдийн хувьд хангалттай цаг гараагүй тул найз нөхөд, хамаатан садантайгаа өнгөрөөх цаг нь буурчээ. Энэ явдал нь ажлын ачаалал, гэрт хүлээсэн үүрэг хариуцлага өндөртэй хэсэг буюу төрийн салбарт ажиллагсдад түлхүү тохиолджээ.

“Ээж, аав дээрээ ч очиж чадаагүй, заримдаа хоол хүнс аваачиж өгөх гэж л ороод гардаг байсан. Гэр бүлээрээ гадагш гарах нь байхгүй болсон. Үүнд зарцуулах цаг ч гарахаа больсон. Найз нөхөд, гэр бүлтэйгээ харилцан харилцаа хөндийрсөн.”
(Их сургуулийн багш эмэгтэй)

УР ЧАДВАР АХИУЛАХ, АЛБАН ТУШААЛ ДЭВШИХЭД УЧРАХ СААД

Ярилцлагад оролцсон зарим хүмүүс цар тахлын үеэр ажил хийхэд зарим талаар эерэг үр дагавар илэрч байсныг дурдсан. Мэдээллийн технологи зэрэг салбарын мэдлэг, ур чадвар бүхий эмэгтэйчүүд зайнаас ажиллах үед технологийн хэрэглээг сайжруулснаар илүү үнэ цэн бүрдүүлж чаджээ. Цаг хугацааны боломж гарсан тохиолдолд зарим эмэгтэйчүүд шинэ ур чадвар, мэдлэгт суралцсаны тоонд оёдол хийх, сэтгэл судлал, мэдээллийн технологи зэрэгт ажил хийгээгүй үедээ суралцсан байна.

Нөгөө талаар ярилцлагад оролцсон хүмүүсийн хувьд цар тахлаас үүдэн өөрийн албан тушаал, ажил мэргэжил ахих төлөвлөгөөг өөрчлөх, хойшлуулах шаардлагатай болжээ. Төрийн албан хаагч хоёр эмэгтэй цар тахал эхлэхээс өмнө ажил хөдөлмөрийн хувьд дэвших тодорхой төлөвлөгөөтэй байсан ажлын байраа хадгалан үлдэхийн тулд хойшлуулах хэрэгтэй

болжээ. Өөр хоёр ярилцагч санхүүгийн хүндрэлээс шалтгаалан цааш сурах төлөвлөгөөгөө хойшлуулжээ. Мөн хоёр оролцогч докторын зэргээр суралцахаар бүртгүүлсэн байсан ч цар тахлын үеэр ачаалал нэмэгдсэн, академик судалгаа хийх нөөц эх үүсвэр багассан зэргээс шалтгаалан төлөвлөгөөг

хойшлуулжээ. Өөр нэг оролцогч эмэгтэйн ажил олгогч нь сургалтын төлбөрийг нь төлөхөөр амласан байсан ч цар тахлаас үүдэн хойшлуулж, одоо ч энэ боломж бүрэн бүрдээгүй байна.



Фото: TAF Mongolia,
Эмэгтэйчүүдийн бизнес төвийн
төсөл

5. БОДЛОГЫН НӨЛӨӨЛӨЛ

Цар тахал, хөл хорионоос (ялангуяа сургуулийн үйл ажиллагааг зогсоох) жендерийн ялгаатайгаар үүдсэн нөлөөлөл нь бага насны хүүхэдтэй эцэг эхчүүд, асран хамгаалагч нарт харилцан ялгаатай үйлчилжээ. Судалгаанд оролцсон олон эмэгтэйчүүдийн хувьд хүүхдээ харахын зэрэгцээ бүтэн цагаар ажиллах нь боломжит, үр дүнтэй сонголт болж чадсангүй. Цар тахал эхлэхээс өмнө эрэгтэйчүүдтэй харьцуулбал 2 дахин илүү цагийг эмэгтэйчүүд хүүхэд асрах болон гэрийн ажилд зарцуулж байжээ. Энэхүү тооцоогоор гарсан утга нь “цалинтай бүтээлч ажил” эрхэлдэг эмэгтэйчүүд дээр ч буураагүй харагдаж байна.³⁰ Цар тахал, авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ нь эмэгтэйчүүдийн, ялангуяа төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн ажлын ачааллыг нэмэгдүүлж, хүүхэд харах, асрахад бусдаас хамааралтай байдлыг нь улам нэмэгдүүлжээ.

Бодлогын сул талууд:

КОВИД-19 цар тахлын эсрэг арга хэмжээ нь санхүүгийн сөрөг нөлөөг бууруулахад голлон төвлөрчээ. Сургууль хаагдсанаас үүдэн хүүхдүүд сургуулийн өдрийн хоол зэрэг хөтөлбөрт хамрагдахгүй болсонтой холбоотойгоор хүүхдийн мөнгөн тэтгэлгийг нэмэгдүүлсэн ч өрхийн түвшинд хүүхэд асрах ажил нэмэгдэж, ачаалал үүсгэхийг тооцоогүй байна. Тиймээс бодлого төлөвлөх, хэрэгжүүлэхэд жендерийн шинжилгээг илүү сайн, тогтмол хийж байх шаардлагатай.

Төр, хувийн хэвшлийн ихэнх байгууллага төрөөс гаргасан заавар, журам, чиглэлийг даган мөрдөж, өөрийн ажилтнуудад цалинтай чөлөө олгох, ажлын цагийг хорогдуулах, хөл хорионы үеэр зайнаас ажиллах боломж олгох (ялангуяа 12-оос доош насны хүүхэдтэй эхчүүдэд) зэрэг сонголтод боломжуудыг бий болгохоор хичээн ажиллажээ. Гэвч байгууллагын төрөл, удирдлага зэрэг олон шалтгаанаас хамааран сонголтуудыг харилцан адилгүй бий болгосон тул харилцан адилгүй үр дүн гарчээ. Тиймээс бодит хэрэг дээр хэрэгжилт нь үр дүнтэй байсангүй.

Эмэгтэй ажилтнуудынхаа онцлог нөхцөл байдлыг, жишээ нь хүүхдийн нас, хүүхдийн тоо, гэр бүлийн орчин, өрхийн гишүүдийн тоо, амьжиргаа зэргийг ажил олгогч нар харгалзан үзээгүй байна. Мэдээллээс үзвэл Засгийн газрын шийдвэрийн дагуу төрийн байгууллагууд 12-оос доош насны хүүхэдтэй эмэгтэйчүүдэд уян хатан ажиллах боломж олгосон ч (1) КОВИД-19 цар тахлын үеэр төрийн албан хаагчдын

ажлын ачаалал ихээр нэмэгдсэн, (2) төрийн алба, хувийн хэвшил гэдгээс хамааран Засгийн газрын шийдвэрийг өөр өөрөөр хэрэгжүүлсэн, (3) цар тахлын үед эмэгтэй төрийн албан хаагчдад дэмжлэг үзүүлэх чадавх төрийн байгууллагуудад байгаагүй, гэрээсээ ажлаа хийхэд шаардлагатай зүйлсээр хангаж өгөөгүй хэмээх шалтгааны улмаас энэхүү шийдвэр нь эмэгтэйчүүдийн ажлын ачааллыг бууруулаагүй ажээ.

Бодлогын сул талууд:

Flexible working options were not tailored to the reality of different sectors such as the public or service sector. Interpretation and uptake of working from home or paid leave policies varied across businesses and sectors. Women who could work from home lacked equipment and affordable internet access to be able to do so. This raises questions on how such policies can be adapted to be more responsive to those working on public and private sectors, taking into account the specific circumstances of women, such as their age, social, economic status, the specifics and status of employment, income level, the needs and requirements of different groups of women, etc. Measures such as making daycare or kindergartens available for workers in essential industries during a pandemic might be considered.

Ажлын уян хатан сонголтуудыг бий болгож өгсөн нь бодит хэрэг дээр төр болон хувийн хэвшил зэрэг харилцан ялгаатай салбарын бодит байдалтай нийцсэнгүй. Бизнесийн байгууллага, салбар бүр дээр гэрээс ажиллах эсвэл цалинтай чөлөө олгох бодлого ялгаатай хэрэгжжээ. Гэрээсээ ажиллах боломжтой

эмэгтэйчүүдэд тоног төхөөрөмж болон хямд үнэтэй интернэт дутмаг байжээ. Үүнээс үүдэн ийм төрлийн бодлогыг төр болон хувийн хэвшилд ажиллагсдын боломжид хэрхэн нийцүүлэх, үүнд эмэгтэйчүүдийн онцлог нөхцөл байдлыг (жишээ нь нас, нийгэм эдийн засгийн статус, эрхэлж буй ажлын онцлог, орлогын хэмжээ, олон бүлгийн онцлог хэрэгцээ шаардлага) харгалзан үзэх шаардлагатай байсныг харуулж байна. Чухал ач холбогдолтой салбарын ажилтнуудад зориулан цар тахлын үеэр өдөр өнжүүлэх эсвэл цэцэрлэг ажиллуулах зэрэг арга хэмжээг судлан үзэх болох юм.

Олон эмэгтэй энэ үеэр өөрийн гэр бүлийнхний дэмжлэгт найдахаас өөр сонголтгүй болжээ. Нийгмийн дэмжлэг үзүүлэх тогтолцоо нь ихэнхдээ гэр бүлийн нэг эсвэл хоёр гишүүний хүрээнд л хэрэгжиж байна. Гэр бүл, өрхийн гишүүдээс ямар нэгэн дэмжлэггүй эмэгтэйчүүд ажлаас гарахаас өөр аргагүйд хүрч, улмаар санхүүгийн хүндрэлтэй нүүр тулжээ. Монгол Улсын Засгийн газраас энэхүү судалгааг гүйцэтгэсэн цаг хугацаанд 18 хүртэлх насны хүүхдэд олгох сар тутмын мөнгөн тэтгэмжийг 5 дахин нэмэгдүүлж, сургууль хаагдсан, сургуулийн өдрийн хоол хөтөлбөр тасалдсан хэсгийг нөхөн олгосон байна. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлсэн ч хүнсний баталгаат байдал асуудалтай хэвээр үлджээ.³¹

Бодлогын сул талууд:

Сургуулиуд хаагдсан үед ажил эрхэлж буй эхчүүдэд зориулсан илүү өргөн хүрээний нийгмийн дэмжлэгийн тогтолцоо эсвэл хүүхэд харах механизм (жишээ нь хямд үнэтэй хүүхэд харах үйлчилгээ) байхгүй байв.

Түүнчлэн хүүхэд харах өөр сонголт байхгүйн улмаас ажил хийхээ больж буй эмэгтэйчүүдэд зориулсан дэмжин туслах механизм байхгүй. Түүнчлэн эмэгтэйчүүд нь гэр орны болон хүүхэд асрах нэмэлт үүргийг хүлээж буй нь тодорхой байна. Засгийн газрын хувьд гэрийн ажил, хүүхэд асрах чиглэлд эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэн, тэд энэхүү үүргийг тэгш хуваан гүйцэтгэж байхыг дэмжих жендерийн тэгш байдлыг дэмжих бодлогын арга хэмжээг судлан үзэхийг зөвлөж байна. Гэрийн үүрэгт

ажлыг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд хуваан гүйцэтгэдэг болгох арга хэмжээний тоонд асрах, хүүхэд харах чиглэлээр цалинтай ажлын байрыг олноор бий болгож, тэгш, шударга цалин орлогыг хангаж, гэр орны болон асран хамгаалах орчныг сайжруулах зэрэг багтах ба эдгээрийг харгалзан үзэх нь зүйтэй.

Засгийн газраас мөн КОВИД-19 цар тахлын үеэр эдийн засгийг эрчимжүүлэх болон иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын олон арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Эдгээр арга хэмжээнд 0-18 хүртэлх насны бүх хүүхдэд олгох хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлэх, хэрэгцээт өрхийн гишүүдэд хүнсний эрхийн бичиг олгох, сар тутмын нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, татвараас чөлөөлөх болон татвар төлөх хугацааг хойшлуулах зэрэг арга хэмжээ багтжээ. КОВИД-19 цар тахлаас үзүүлэх нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бууруулахаар Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хүчин чармайлт нь тодорхой хэмжээнд амжилттай байсан ч зарим эмэгтэйчүүд орхигдсон нь ажиглагдлаа. Ярилцлагад хамрагдсан эмэгтэйчүүдийн зүгээс хэлэхдээ хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмсэн, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн зэрэг нь санхүүгийн хувьд дэмжлэг болсон ч эмэгтэйчүүдэд өөрийн ажлаа тасралтгүй үргэлжлүүлэх хийх чиглэлд үр дүнгүй байжээ.

Хүүхдийн мөнгөн тэтгэмж нь бүх эмэгтэйчүүд, тэдний гэр бүлд санхүүгийн хувьд дэмжлэг болсон. Эмэгтэйчүүдийн ихэнх нь хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хадгаламжийн дансанд нь үргэлжлүүлэн хуримтлуулжээ. Ажил, орлогогүй болсон эмэгтэйчүүдийн хувьд хүүхдийн мөнгөн тэтгэмж нь шаардлагатай хүнс худалдан авах, хүүхдүүдийн тодорхой үйл ажиллагааны зардлыг төлөх боломжийг хангажээ. Нийтэд нь авч үзвэл ихэнх эмэгтэйчүүд цар тахлын үеэр санхүүгийн сөрөг нөлөөллийг мэдэрч, орлого нь бүрэн эсвэл хэсэгчлэн буурчээ. Үүний зэрэгцээ цар тахлын үеэр ажлаа үргэлжлүүлэн хийж байсан эмэгтэйчүүдийн зүгээс тэдний ажилтай нь холбоотой зардал өссөн болохыг дурдсан.

Бодлогын сул талууд:

Татвараас хөнгөлөх, чөлөөлөх арга хэмжээ нь ихэнхдээ том бизнесийн байгууллага, өндөр орлоготой ажил эрхлэгчдэд илүү өгөөжтэй байдаг. Харин энэ хөнгөлөлт, чөлөөлөлт нь төрийн албан хаагчид, болон хувиараа хөдөлмөр эрхэлж буй хүмүүст хамаарахгүй ба эдгээр нь эмэгтэйчүүд түлхүү ажилладаг салбарууд юм. Энэхүү үр дүн нь хөнгөлөх, чөлөөлөх механизм нь илүү дэвшилтэт, хүртээмжтэй эсэх, ийм төрлийн арга хэмжээг цаашид Монгол Улсад урт хугацаанд хэрэгжүүлэхэд хэрхэн илүү тэгш хүртээмжтэй хэрэгжүүлэх зэрэгтэй холбоотой асуултуудыг бий болгож байна.

ХАВСРАЛТ: АРГА ЗҮЙ

Баримт бичгийн шинжилгээ

Судалгааны баг нь 2020 оны 10 болон 11 дүгээр саруудад судалгааны анхдагч материал болох баримт бичгийн судалгааг хийж, хөдөлмөр эрхэлж буй, бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдэд КОВИД-19 цар тахлын үзүүлсэн нөлөөлөлтэй холбоотой мэдээлэл, баримт нотолгоог цуглуулсан. Энэхүү анхан шатны судалгааны хүрээнд хамаарах Засгийн газар болон хамаарах шатны Засаг даргын тогтоол, захирамжууд, мөн олон улсын донор байгууллагууд, бизнесийн байгууллагууд, ТББ-уудын бэлтгэн гаргасан, ялангуяа НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Дэлхийн Банкны гаргасан судалгааны баримт материалуудыг хамруулсан.³²

Хагас бүтэцчилсэн ярилцлага

Судалгааны баг нь 2021 оны 1 болон 2 дугаар саруудад нийслэлийн төр болон хувийн хэвшилд ажилладаг эмэгтэйчүүдтэй 16 багц хагас бүтэцчилсэн чанарын ярилцлагыг хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн хэмжээнд КОВИД-19 цар тахлаас үүдэн хязгаарлалт тогтоосон байсны улмаас бүх ярилцлагыг утсаар болон Zoom программ ашиглан интернэтээр хийсэн.

Судалгааны баг нь зорилтот түүвэрлэлтийн арга зүйг баримтлан ажиллалаа. Ярилцлагад хамруулсан бүх эмэгтэйчүүд 12-оос доош насны нэг болон дээш тооны хүүхэдтэй эмэгтэйчүүд байсан. Төр, хувийн хэвшлийн хооронд харьцуулалт хийх боломжийг хангахын тулд цар тахал эхлэхэд төрийн албанд болон хувийн хэвшилд ажиллаж байсан эмэгтэйчүүдийг ижил тоотой байхаар сонгон авч, ярилцлагуудыг хийсэн. Эдгээр хоёр бүлэгт цар тахлын үеэр ажлаа үргэлжлүүлэн хийсэн болон ажиллахаа больсон эмэгтэйчүүд хамрагдсан. Ажлаа үргэлжлүүлэн хийсэн эмэгтэйчүүдийн хувьд зарим нь ажилдаа биечлэн очиж байсан бол зарим нь гэрээсээ ажлаа гүйцэтгэсэн эмэгтэйчүүд байна. Судалгааны баг нь мөн түүврийн олон талт байдлыг хангахын тулд нийслэлийн өөр өөр дүүргүүдэд (гэр хороолол болон орон сууцны хороолол) харьяалагдах, өөр өөр ажил мэргэжилтэй эмэгтэйчүүдийг сонгосон. Тухайн оролцох эмэгтэйчүүдийг Азийн Сангийн хэрэгжүүлж буй төсөл,

өөрийн сүлжээгээр дамжуулан тогтоосон.

Ярилцлага нэг бүрийг 60- 90 минутад багтаан хийж, оролцогчдын зөвшөөрлөөр ярилцлагуудыг аудио форматаар бичсэний зэрэгцээ, тусгайлсан тэмдэглэл хөтлөгч ажиллуулан гараар бичиж авсан.

Улмаар тухайн яриаг бичвэр хэлбэрт хөрвүүлэн, Англи хэлэнд орчуулсан. Англи хувилбарыг аль болох зөв, ойлгомжтой байлгахын тулд тодорхой хэмжээний хүчин чармайлт гарган, анхны утгыг алдуулахгүй байхад анхаарсан. Ярилцлага нэг бүрийн бичвэрийг кодолж, сэдэвчилсэн болон судалгааны хөрвүүлэх шинжилгээ хийх боломжийг хангасан.

Судалгааны ёс зүй

Судлаачдын зүгээс феминист, хүний эрхэд суурилсан хандлагыг баримталж, урьдчилан баталсан ёс зүйн зарчмуудыг баримтлан тодорхой протокол болгон, судалгааны багийн бүхий л гишүүдэд тодорхой ойлгуулан, даган мөрдөж ажилласан. Үүнд оролцогчийн нууцлалыг даган мөрдөх, хүртээмж болон үзэл бодлын олон ургалч байдлыг хангах, мэдээлэл өгсний үндсэн дээр зөвшөөрөл авч байх зэрэг багтсан.

Хязгаарлалтууд

Ярилцлагын биечлэн хийх боломжгүй байсан нь судалгаанд тодорхой хэмжээний сорилтуудыг учруулсан. Практик түвшиндээ зарим газарт интернэтийн холболт муу байх үед хийгдэж байсан ярилцлага тасалдан, асуултуудын дараалал, урсцад сөргөөр нөлөөлж байсан. Утсаар эвэл онлайнаар ярилцлага хийх нь ярилцлага нь оролцогчид итгэл төрүүлэх талаар сорилтууд учруулсан ба зарим тохиолдолд хариулт өгөхдөө хэр нээлттэй, шударга байхад нь нөлөөлж байв.

Зарим оролцогчийн зүгээс өөрийн ажил олгогчийн талаарх мэдээллийг ил тод болгох, Засгийн газрын шийдвэрийн талаар өөрийн үзэл бодлоо илэрхийлэхээс болгоомжилж байсан.

ТЭМДЭГЛЭЛ

- 1 Sen, Amartya (n.d.). *Capability Approach*; Sen, Amartya (n.d.). *The Multi-dimensional Inequality Framework*; Kabeer, N. (2016). *Leaving no one behind: the challenge of intersecting inequalities*; Leach, M., Gaventa, J., Justino, P., Caillods, F. and Denis, M. (2016). "Challenging inequalities: pathways to a just world; key messages and main contributions," in International Social Science Council. University of Sussex (UK), Institute of Development Studies, and UNESCO.; Director-General (2016). *World Social Science Report 2016: Challenging Inequalities: Pathways to a Just World*.
- 2 Гамшгаас хамгаалах тухай Монгол улсын хуулийн дагуу бэлэн байдлын гурван зэрэглэл байх ба эдгээр нь 1. Өдөр тутмын бэлэн байдал (аюулын хэмжээ доогуур), 2. Өндөржүүлсэн бэлэн байдал (аюулын зэрэг өндөр), 3. Олон нийтийн бэлэн байдал (аюулын зэрэг хамгийн өндөр) зэрэг багтана.
- 3 Хууль зүйн үндэсний хүрээлэн (2020). "УИХ-аас КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх тухай хуулийг баталлаа." <https://nli.gov.mn/?p=3172&lang=en>.
- 4 Монгол улсын ЗГ (2020). "МУЗГ-ын 30 дугаар тогтоол." <https://legalinfo.mn/mn/detail/15030>.
- 5 Монгол улсын ЗГ (2020). "МУЗГ-ын 139 дүгээр тогтоол." <https://legalinfo.mn/mn/detail/15254>.
- 6 ҮСХ, Дэлхийн Банк (2020). "Коронавируст халдвараас өрхөд үзүүлсэн нөлөөллийн судалгаа." <https://documents1.worldbank.org/curated/en/213701595317758212/pdf/Results-of-Mongolia-Covid-19-Household-Response-Phone-Survey-Round-1.pdf>.
- 7 Фридрих Эбертын сан (2020). "КОВИД-19 цар тахлаас жижиг бизнес эрхлэгчдэд үзүүлсэн нөлөө." <http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/16946.pdf>.
- 8 НҮБХХ (2020). "КОВИД-19 цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс эмзэг бүлэг болон нэмүү өртгийн сүлжээнд үзүүлсэн нөлөөллийн нийгэм-эдийн засгийн түргэвчилсэн үнэлгээ." <https://online.fliphtml5.com/dswdd/igbz/?1593564145088#p=1>.
- 9 НҮБХХ, Жендерийн үндэсний хороо, АХБ (2021). "КОВИД-19 цар тахлаас Монгол улсын охид, эмэгтэйчүүдэд үзүүлсэн нөлөөллийн нийгэм, эдийн засгийн үнэлгээ." <https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/-Covid-19-impact-on-women-and-girls-in-mongolia--study.html>.
- 10 ҮСХ-ны мэдээллээр Монгол улсад буй нийт 69,787 өрх толгойлсон эмэгтэй бүхий өрхийн 43.1% нь 19 хүртэлх насны хүүхэдтэй ба гэр бүл салалтын ихэнх тохиолдолд хүүхдийг эмэгтэйчүүд авч үлддэг байна.
- 11 НҮБХХ (2020). "КОВИД-19 цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс эмзэг бүлэг болон нэмүү өртгийн сүлжээнд үзүүлсэн нөлөөллийн нийгэм-эдийн засгийн түргэвчилсэн үнэлгээ." <https://online.fliphtml5.com/dswdd/igbz/?1593564145088#p=1>.
- 12 Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO) (2020). "КОВИД-19 болон хөдөлмөрийн зах зээл: Нөлөөлөл болон хариу арга хэмжээ." https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_742635.pdf.
- 13 Б.Мөнхбаяр, Г.Батхуяг (2020). "КОВИД-19 цар тахлаас бизнест үзүүлсэн нөлөөллийн судалгаа." https://www.ufe.edu.mn/pdf/2020/Covid_short1.pdf.
- 14 ҮСХ, Дэлхийн Банк (2020). "Коронавируст халдвараас өрхөд үзүүлсэн нөлөөллийн судалгаа." <https://documents1.worldbank.org/curated/en/213701595317758212/pdf/Results-of-Mongolia-Covid-19-Household-Response-Phone-Survey-Round-1.pdf>.
- 15 ҮСХ, Дэлхийн Банк (2020). "Коронавируст халдвараас өрхөд үзүүлсэн нөлөөллийн судалгаа." <https://documents1.worldbank.org/curated/en/213701595317758212/pdf/Results-of-Mongolia-Covid-19-Household-Response-Phone-Survey-Round-1.pdf>.
- 16 НҮБХХ (2020). "КОВИД-19 цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс эмзэг бүлэг болон нэмүү өртгийн сүлжээнд үзүүлсэн нөлөөллийн нийгэм-эдийн засгийн түргэвчилсэн үнэлгээ." <https://>

online.fliphtml5.com/dswdd/igbz/?1593564145088#p=1.

- 17 НҮБХХ, Жендерийн үндэсний хороо, АХБ (2021). "КОВИД-19 цар тахлаас Монгол улсын охид, эмэгтэйчүүдэд үзүүлсэн нөлөөллийн нийгэм, эдийн засгийн үнэлгээ." <https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/-Covid-19-impact-on-women-and-girls-in-mongolia--study.html>.
- 18 А.Гантуяа (2020). "КОВИД-19 цар тахлаас Монгол улсын хөдөлмөрийн зах зээл дээрх жендерийн тэгш байдалд үзүүлсэн нөлөөлөл." <https://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/17162.pdf>.
- 19 НҮБХХ, Жендерийн үндэсний хороо, АХБ (2021). "КОВИД-19 цар тахлаас Монгол улсын охид, эмэгтэйчүүдэд үзүүлсэн нөлөөллийн нийгэм, эдийн засгийн үнэлгээ." <https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/-Covid-19-impact-on-women-and-girls-in-mongolia--study.html>.
- 20 А.Гантуяа (2020). "КОВИД-19 цар тахлаас Монгол улсын хөдөлмөрийн зах зээл дээрх жендерийн тэгш байдалд үзүүлсэн нөлөөлөл." <https://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/17162.pdf>.
- 21 НҮБХХ, Жендерийн үндэсний хороо, АХБ (2021). "КОВИД-19 цар тахлаас Монгол улсын охид, эмэгтэйчүүдэд үзүүлсэн нөлөөллийн нийгэм, эдийн засгийн үнэлгээ." <https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/-Covid-19-impact-on-women-and-girls-in-mongolia--study.html>.
- 22 НҮБХХ, Жендерийн үндэсний хороо, АХБ (2021). "КОВИД-19 цар тахлаас Монгол улсын охид, эмэгтэйчүүдэд үзүүлсэн нөлөөллийн нийгэм, эдийн засгийн үнэлгээ." <https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/-Covid-19-impact-on-women-and-girls-in-mongolia--study.html>.
- 23 НҮБХХ, Жендерийн үндэсний хороо, АХБ (2021). "КОВИД-19 цар тахлаас Монгол улсын охид, эмэгтэйчүүдэд үзүүлсэн нөлөөллийн нийгэм, эдийн засгийн үнэлгээ." <https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/-Covid-19-impact-on-women-and-girls-in-mongolia--study.html>.
- 24 НҮБХХ, Жендерийн үндэсний хороо, АХБ (2021). "КОВИД-19 цар тахлаас Монгол улсын охид, эмэгтэйчүүдэд үзүүлсэн нөлөөллийн нийгэм, эдийн засгийн үнэлгээ." <https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/-Covid-19-impact-on-women-and-girls-in-mongolia--study.html>.
- 25 Дэлхийн Банк (2021). "Монгол улсын эдийн засгийн төлөв байдал – хариу арга хэмжээнээс сэргээн босголт руу." <https://documents1.worldbank.org/curated/en/871221612896025238/pdf/Mongolia-Economic-Update-From-Relief-to-Recovery.pdf>.
- 26 А.Гантуяа (2020). "КОВИД-19 цар тахлаас Монгол улсын хөдөлмөрийн зах зээл дээрх жендерийн тэгш байдалд үзүүлсэн нөлөөлөл." <https://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/17162.pdf>.
- 27 НҮБХХ, Жендерийн үндэсний хороо, АХБ (2021). "КОВИД-19 цар тахлаас Монгол улсын охид, эмэгтэйчүүдэд үзүүлсэн нөлөөллийн нийгэм, эдийн засгийн үнэлгээ." <https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/-Covid-19-impact-on-women-and-girls-in-mongolia--study.html>.
- 28 Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим (MNCCI) (2020). "КОВИД-19 цар тахлаас хувийн бизнес эрхлэгчдэд үзүүлсэн нөлөөлөл" <https://www.mongolchamber.mn/resource/mongolchamber/File/2020/12/21/ekt76ujtfvncv34a/new%20tailan%20eng.pdf>.
- 29 УИХ-ын 41 дүгээр тогтоолоор татвараас чөлөөлөгдөж болох бөөн тооны төрийн салбарын байгууллагуудыг заажээ.
- 30 Японы олон улсын хөгжлийн агентлаг (2013). "ЖАЙКА Сэдэвчилсэн үнэлгээ."
- 31 Олон улсын хөдөлмөрийн харилцааны товчоо (n.d.). "Хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрийн тайлан." <https://www.dol.gov/agencies/ilab/resources/reports/child-labor/mongolia>.

- 32 НҮБХХ (2020). "КОВИД-19 цар тахлаас сэргийлэх арга хэмжээнээс эмзэг бүлэг болон нэмүү өртгийн сүлжээнд үзүүлсэн нөлөөллийн нийгэм-эдийн засгийн түргэвчилсэн үнэлгээ." <https://online.fliphtml5.com/dswdd/igbz/?1593564145088#p=1>; Дэлхийн Банк (2020). "Монгол улс: КОВИД-19 халдварын үеийн өрхийн ахриу арга хэмжээний утсаар хийсэн судалгаа." <http://pubdocs.worldbank.org/en/225001608536997834/MNG-HF-phonesurveyR2-Final-EN.pdf>; Erkhembayar, Rychindorj, Dickinson, Emma, Badarch, Darmaa, Narula, Indermohan, Warburton, David, Thomas, Graham Neil, Ochir, Chimedsuren and Manaseki-Holland, Semira (2020). "Early policy actions and emergency response to the Covid-19 pandemic in Mongolia: experiences and challenges." *Lancet Global Health*, Vol. 8, No. 9, pp. e1234-e1241. <https://pubmed.ncbi.nlm.nih.gov/32711684/>; Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим (MNCCI) (2020). "КОВИД-19 цар тахлаас хувийн бизнес эрхлэгчдэд үзүүлсэн нөлөөлөл" <https://www.mongolchamber.mn/resource/mongolchamber/File/2020/12/21/ekt76ujtfvncv34a/new%20tailan%20eng.pdf>; НҮБ ХС (2020). "Монгол улс: Шинэ коронавирусын (КОВИД-19) нөхцөл байдлын тайлан No. 4." <https://www.unicef.org/media/81346/file/Mongolia-Covid19-SitRep-12-August-2020.pdf>.



The Asia Foundation

Азийн Сан нь эрч хүчтэй, хөгжин цэцэглэж буй Ази тивд амьжиргааг сайжруулах зорилго бүхий ашгийн бус, олон улсын хөгжлийн байгууллага юм. Нэгэн жарны туршид үйл ажиллагаа явуулсан туршлага, улс орнуудын талаарх өргөн хүрээний мэдлэг дээр суурилсан бидний үйл ажиллагаа нь сайн засаглал, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэн чадавхжуулах, жендерийн тэгш байдлыг хангах, эдийн засгийн тэгш хүртээмжийн өсөлтийг дэмжих, байгаль орчин болон уур амьсгалын асуудал, бүс нутгийн болон олон улсын харилцаа зэрэг чиглэлд төвлөрдөг.